



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2008 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 22

Өндөрхаан

Комисс томилох тухай

Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 2 дугаар бүлгийн 4 дүгээр зүйлийн 3 дахь заалт болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлж сахилга, дэг журмыг бэхжүүлэх, үйлчилгээний чанар, эрүүл ахуйн мөрдлөгийг хангах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэхэд зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллах аймгийн комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, "Согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэхэд зөвшөөрөл олгох, хяналт тавих журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн холбогдох заалтууд, энэ захирамжаар батлагдсан журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, үйлчилгээний газруудын дарга /захирал/ нарт даалгасугай.

3.Батлагдсан журмыг аж ахуйн нэгж, иргэдэд сурталчилах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэс, Цагдаагийн газар, Стандартчилал хэмжилзүйн төв, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.


4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 5 сарын 23-ны өдрийн 98 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Д.БОЛДБААТАР

02 063



Аймгийн Засаг даргын 2008 оны
...сарын ...-ны өдрийн ...тоот
захирамжийн нэгдүгээр хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ,
ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХЭД ХЯНАЛТ ТАВЬЖ
АЖИЛЛАХ АЙМГИЙН КОМИСС

- Комиссын дарга: -Аймгийн Засаг даргын орлогч
- Нарийн бичгийн дарга: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрлэл, дэд бүтэц байгаль орчны бодлого, зохицуулалтын хэлтсийн Худалдаа, үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрлэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрлэл, дэд бүтэц, байгаль орчны бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
 - Мэргэжлийн хяналтын газрын дарга
 - Татварын хэлтсийн дарга
 - Стандартчилал хэмжилзүйн төвийн дарга -
 - Цагдаагийн газрын Хэв журмын ахлах байцаагч -
 - Онцгой байдлын хэлтсийн Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч

**СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА,
ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХЭД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ,
ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг: Нийтлэг зүйл

- 1.1. Монгол улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай", "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн дагуу согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, согтууруулах ундааны худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээнд хяналт тавихад энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.2. Олон улсын гэрээнд өрөөр заагаагүй бол аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулах гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, олон улсын үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад нэгэн адил хамаарна.

Хоёр: Ерөнхий шаардлага

- 2.1. Согтууруулах ундааны үйлдвэрлэл, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" болон "Архидан согтуурахтай тэмцэх тухай" Монгол улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж бусад эрх бүхий байгууллагуудаас нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан шийдвэрүүдийн хүрээнд явуулна.
- 2.2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгж нь тухайн орон нутгийн Засаг даргын баталсан цагийн хуваарийн дагуу ажиллана.
- 2.3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжүүд нь зохих журмын дагуу зөвшөөрөл авсан согтууруулах ундааны үйлдвэрүүд, бөөний худалдааны газруудаас эрүүл ахуйн чанарын шаардлага хангасан баталгаатай, барааны тэмдэгтэй бүтээгдэхүүн авч үйлчилгээ эрхэлнэ.
- 2.4. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжүүд нь орон нутгийн үйлдвэрийг дэмжих зорилгоор тэдний бүтээгдэхүүнийг борлуулахад түлхүү анхаарна.
- 2.5. Согтууруулах ундааны үйлдвэрлэл, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгж нь нягтлан бодох бүртгэлийн ажлыг мэргэжлийн эсвэл мэргэшсэн нягтлан бодогчоор гүйцэтгүүлж, санхүүгийн тайланг улирал бүр үнэн зөв гаргаж хэвшсэн, татвар, шимтгэл, хураамжийн өргүй ажилласан байна.
- 2.6. Үйлдвэрлэл, үйлчилгээний технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн болон согтууруулах ундаа худалдах стандарт нөхцөлийг хангасан зоогийн газар, кафе, бааранд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгоно.

**Гурав: Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэдэг
аж ахуйн нэгжид тавих шаардлага**

- 3.1. Согтууруулах ундаа үйлдвэрлэх аж ахуйн нэгж нь Засгийн газрын 2001 оны 171 дүгээр тогтоол, ХААҮ-ийн сайдын 1998 оны 111 тоот тушаал, аймгийн Засаг даргын захирамж, бусад эрх бүхий байгууллагуудаас дагаж мөрдөхөөр гаргасан шийдвэрүүдийн заалтыг бүрэн хангасан байна.
- 3.2. Согтууруулах ундаа үйлдвэрлэх аж ахуйн нэгж нь Согтууруулах ундааны үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд хяналт тавих аймгийн комисст дүгнэлт, бусад акт баримт ирүүлэх бөгөөд аймгийн Засаг дарга саналаа ХХААЯаманд өргөн барьж тус яамнаас шийдвэр гарсаны дараа үйлдвэрлэл явуулах эрхтэй болно.
- 3.3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгж нь "Барааны тэмдэг, аж ахуйн нэгж нэрийн тухай" хуульд заасны дагуу өөрийн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний барааны тэмдэг болон аж ахуйн нэгж нэрийг бүртгүүлж гэрчилгээ авсан байна.

**Дөрөв: Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ
эрхлэхэд тавих шаардлага**

- 4.1. Согтууруулах ундаа худалдах хүнсний дэлгүүр, түүгээр үйлчлэх зоогийн газар, баар, кафе нь худалдаа, нийтийн хоолны барилгын норм, дүрэм, үйлдвэрлэл, үйлчилгээний технологийн дагуу оновчтой төлөвлөгдсөн зохион байгуулалт бүхий ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, галын аюулгүй байдлыг хангасан, шаардлагад нийцсэн гэрэлтүүлэг, агааржуулалтын системтэй, худалдан авагч, үйлчлүүлэгчдийн ая тухыг хангахуйц тохижилттой байна.
- 4.2. Согтууруулах ундаа худалдах хүнсний дэлгүүр, түүгээр үйлчлэх зоогийн газар, баар, кафе нь хүнсний бараа бүтээгдэхүүн хадгалах, хөргөх төхөөрөмж ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан төрөлжсөн агуулахтай байх

- 4.3. Хүнсний бөөний худалдааны төв нь аймгийн Засаг даргын захирамжаар үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан байна.
- 4.4. Согтууруулах ундаа худалдах хүнсний дэлгүүр, түүгээр үйлчлэх зоогийн газар, баар, кафе нь кассын машин ажиллуулж, баталгаажуулсан сав жин хэмжүүр ашиглана.
- 4.5. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх зөвшөөрөл авсан газарт ажиллагсад нь **мэргэжлийн, 21 нас хүрсэн, эрүүл мэндийн хувьд тэнцсэн, хуулийн хариуцлага хүлээх чадвартай** байна.
- 4.6. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгж нь байр, орчны тохижилт, хаяг реклам чимэглэл, гэрэлтүүлгийг аймгаас тавьж буй шаардлага, өнгө үзэмжид нийцүүлэн хийхээс гадна орчны зам, талбайн цэвэрлэгээг 50 метрийн тойрогт хариуцна.
- 4.7. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгж нь согтууруулах ундаа худалдан авах гэрээ байгуулж, гэрээт байгууллагаасаа **падантай, улсын байцаагчийн эх тэмдэгтэй шинжилгээний дүгнэлттэй, онцгой албан татварын тэмдгийн зөрчилгүй** согтууруулах ундаагаар үйлчилнэ.
- 4.8. Согтууруулах ундаа худалдах, хүнсний дэлгүүр, түүгээр үйлчлэх зоогийн газар, баар, кафе нь үйлчилгээний онцлогийг тусгасан дараахь нөхцөлийг хангасан байна. Үүнд:

а) Хүнсний дэлгүүр

1. **Худалдаа, худалдааны газрын үйлчилгээ MNS:5021-2007** стандартын шаардлага хангасан байна.
2. Хөдөлмөрчдөд үйлчлэх дэлгүүрийн үйлчилгээний заалны талбайн хэмжээ **40м.кв-с** доошгүй байх бөгөөд **зориулалтын агуулах, ажиллагсдын амрах өрөөтэй** байна.
3. Дэлгүүр нь хүнсний гол нэрийн барааг /мах, махан, сүү, сүүн бүтээгдэхүүн, талх, гурил, шар, цагаан, хүүхдийн будаа, элсэн чихэр, ургамлын тос, төмс, хүнсний ногоо/ гурваас доошгүй хоногоор зориулалтын агуулахад нөөцөлсөн байна.

б) Зоогийн газар

1. Зоогийн газар нь ариун цэврийн дүрмийн шаардлага хангахуйц хоол зөөх болон хэрэглсэн аяга таваг зөөх урсгалтай, үйлдвэрлэлийн байр нь технологийн шаардлагад нийцсэн бэлтгэлийн өрөө, халуун болон хүйтэн боловсруулах цехтэй эсвэл зориулалтаар зохион байгуулагдсан ажлын байртай байна.
2. Зоогийн газар нь шаардлага хангасан хоолны цэстэй, түүний дагуу үйлдвэрлэл үйлчилгээ явуулан, **Хоолны газрын үйлчилгээ MNS-4946:2005** стандартыг чанд баримтлана.
3. 50м.кв-с дээш талбайтай үйлчилгээний газарт агаар оруулах, гаргах төхөөрөмжтэй, 28 хүн тутамд гарын угаагуур 1, эрэгтэй, эмэгтэй тус бүр 1 суултуур ногдохоор байна.

с) Кафе

1. Кафе нь энгийн байхаас гадна төрөлжсөн байж болно. Төрөлжсөн кафе нь нэрэндээ тохирсон дотоод, гадаад тохижилттой, өөрийн онцлог агуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулах үйлчилгээтэй байна.
2. Хүүхдэд зориулсанаас бусад төрөлжсөн **кафед 18-аас дээшгүй градустай** дарс, шар айргаар үйлчилнэ.
3. Кафе зөвхөн стандартын шинжилгээ, чанарын баталгаатай бараа бүтээгдэхүүнтатан авч, горимын дагуу хадгалан, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулна.
4. Кафе "Хоолны газрын ариун цэврийн дүрэм"-ийг баримтлан ажиллаж, цэвэрлэгээ, ариутгал устгалыг тогтмол хийж ажиллана.

д) Баар

1. Баар зөвхөн согтууруулах ундаагаар үйлчлэх, хэт чанга хөгжим тавих, нийтийн амгалан тайван байдал алдагдуулах, хэрүүл зодоон гаргах зэрэг үйлчилгээний дэг журам зөрчсөн зохисгүй байдал гаргахгүй байх зарчмыг хатуу баримтлана.
2. Баар нь **Хоолны газрын үйлчилгээ MNS-4946:2005** стандартаар тогтоогдсон байх бөгөөд уг стандартыг чанд баримтлана.
3. Бармены ажлын байр, угаалгын тосгуур, ус буцалгагч, хөргөгч, мөс бэлтгэгч, коктейль найруулагч, шилэн сав хэрэглэлийн тавиур зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.
4. Хувь хүн, аж ахуйн нэгжээс стандартын бус, шинжилгээгүй, хаана үйлдвэрлэсэн нь тодорхойгүй согтууруулах ундааг хүлээн авч худалдах явдлыг бүрэн зогсоож, энэ талаар хийх тэмцлийг хүчтэй болгож ажиллана.
5. Баар нь согтууруулах ундаа болон халуун хоол, зуушаар үйлчлэхээс гадна хүмүүсийн ая тухтай амрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор караоке, шоу тоглолт, биеийн тамир, соёл урлагийн чиглэлийг сурталчлах төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулж ажиллана.

Тав: Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд тусгай зөвшөөрөл олгох

- 5.1 Аймгийн нутаг дэвсгэр дээр согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэхэд зөвшөөрөл олгох асуудлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон комисс гүйцэтгэнэ.
- 5.2 Аймгийн нутаг дэвсгэр дээр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж нь энэхүү журмаар баталсан шаардлагыг хангах, аймгийн комисст дор дурьдсан материалыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:
 1. Татварын албанд бүртгэгдсэн аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ /хуулбар/
 2. Мэргэжлийн хяналтын газрын ажлын байрны дүгнэлт/хуулбар/, санал
 3. Үйлчилгээний тохирлын гэрчилгээ /хуулбар/
 4. Галын аюулгүй байдлын дүгнэлт /хуулбар/

5. Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ /хуулбар/
 6. Татварын хэлтсийн тодорхойлолт
 7. Бүтээгдэхүүн худалдан авах гэрээ /хуулбар/
 8. Тухайн орон нутгийн Засаг даргын санал
 9. Фото зураг /гадна, дотор/ (Шинээр зөвшөөрөл хүсч буй аж ахуйн нэгж, байгууллага)
- 5.3. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх аж ахуйн нэгж өргөдлөө тухайн сумын Засаг даргад гаргана. Өргөдөлд худалдаа, үйлчилгээ эрхлэх нөхцөлийг хангасан тухай баримт бичгүүдийг хавсаргасан байх.
 - 5.4. Өргөдөл материалыг сумын Засаг дарга энэхүү журмын дагуу хянаж, өөрийн саналын хамт аймгийн комисст ирүүлэх.
 - 5.5. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Худалдаа, үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн сум болон байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн материал, мэргэжлийн хяналтын байгууллагын санал дүгнэлтийг үндэслэн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл, дүгнэлтийг аймгийн комисст оруулж хэлэлцүүлнэ.
 - 5.6. Аймгийн комиссын хуралдаан улиралд 1 удаа болох ба комиссоороо тухайн аж ахуйн нэгжид согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох эсэх тухай хэлэлцэж саналыг аймгийн Засаг даргад өргөн барьж захирамжаар батлуулна.
 - 5.7. Комиссын хурлын шийдвэргүйгээр хэн ч согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгохгүйгээс гадна аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгосны дараа согтууруулах ундаагаар үйлчилнэ.
 - 5.8. Иргэд олон түмний шаардлага хүсэлт, мэргэжлийн холбогдох байгууллага, албан тушаалтны санал зэргийг үндэслэн энэхүү журамд заасан шаардлагыг биелүүлээгүй цэгт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг комиссын хурлаар хэлэлцэж хүчингүй болгох ба дахин зөвшөөрөл олгох асуудлыг 6 сараас доошгүй хугацаанд эргэн авч хэлэлцэхгүй.
 - 5.9. Согтууруулах ундаа худалдах хүнсний дэлгүүр нь ердийн болон амралт, баяр ёслолын өдрүүдэд **өглөөний 08.30 цагаас орой 21 цаг хүртэл** ажиллах ба цагийн хуваарийг аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд мөрдөж ажиллана.

Зургаа. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах

- 6.1. Тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол анх олгосон хугацаанаас нь доошгүй хугацаагаар сунгаж болно.
- 6.2. Тусгай зөвшөөрлийн хугацааг дуусахаас **1 сарын өмнө** шаардлагатай материалыг бүрдүүлж холбогдох байгууллагад ирүүлээгүй, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй.

Долоо. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

- 7.1. Тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага түүнийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.
- 7.2. Тусгай зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллага нь түдгэлзүүлсэн шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.
- 7.3. Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага нь тусгай зөвшөөрлийн үйлчлэлийг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд уул зөвшөөрлийг сэргээнэ.

Найм. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

- 8.1. Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага нь дараахь тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.
 - 8.1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан.
 - 8.1.2. Хуулийн этгээд татан буугдсан
 - 8.1.3. Тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон
 - 8.1.4. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа /Зудаа/ буюу ноцтой зөрчсөн
 - 8.1.5. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй
- 8.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл олгосон байгууллага нь шийдвэр гарсанаас хойш 3 хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд бичгээр мэдэгдэнэ.

Ес. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох тухай

- 9.1. Энэ журмын 2, 3, 4, 5-д заагдсан шаардлагыг хангаж согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл авсанаас бусад бүх дэлгүүр, хоолны газар, аж ахуйн нэгжид согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно.

- 9.2. Хүнсний дэлгүүрт спирт, үйлдвэрээс савлагдаагүй задгай пиво худалдах, бүх төрлийн архи, шар айраг, дарсыг савлах буюу хундагалах, аягалаж борлуулахыг хориглоно.
- 9.3. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж нь согтуу хүн болон 21 насанд хүрээгүй хүүхдэд үйлчлэхийг хориглоно.
- 9.4. Тогтоосон цагийн хуваарийг зөрчиж худалдаа үйлчилгээ явуулахыг хориглоно.
- 9.5. Иргэд, албан тушаалтан ажлын байрандаа ажил үйлчилгээ эрхлэж буй үедээ согтууруулах ундаа хэрэглэх, бусдад хэрэглүүлэхийг хориглоно.
- 9.6. Аж ахуйн нэгж аливаа албан тушалтны бичиг, ам шийдвэрээр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 9.7. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл авсан газрууд зөвхөн зөвшөөрөгдсөн байранд худалдаа явуулах бөгөөд баяр ёслол, биеийн тамирын уралдаан тэмцээн, аялал зугаалга зэрэг олон нийтийг хамарсан бүх төрлийн арга хэмжээ зохиогдож байгаа байр, гудамж талбайд, зах, түрээсийн лангуу тасаг, түргэн үйлчилгээний цэгт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно.
- 9.8. "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай", "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хууль согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, үйлчлэх талаар Засгийн газраас гарсан тогтоол болон аймгийн Засаг даргын захирамж, комиссын шийдвэр, энэхүү журмыг зөрчиж үйлдвэрлэсэн буюу импортлосон, татвар төлөөгүй, хяналтын шинжилгээ хийгээгүй, бүтээгдэхүүний чанарын гол үзүүлэлт болох физик, химийн бүрэлдэхүүн лабораторийн болон импортын шинжилгээнд хамрагдаагүй импортлохыг хориглосон согтууруулах ундааг хүлээн авах, худалдаа үйлчилгээнд гаргахыг хориглоно.
- 9.9. Аймгийн Засаг даргын 2002 оны 69 дүгээр захирамжийн дагуу Дэлхийн эрүүл мэндийн өдөр **4 сарын 7**, Эх, үрсийн баярын өдөр **6 сарын 1**, Хичээлийн шинэ жилийн нээлт **9 сарын 1**-ний өдрүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно.

**Арав: Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх
зөвшөөрөл олгохыг хориглох байршил**

- 10.1. Хүүхдийн цэцэрлэг, сургууль, оюутан, сурагчдын дотуур байр зэрэг хүүхдийн байгууллагын байр, клиник, амбулатори, сувиллын байр, хүнс барааны захын байранд.
- 10.2. Зориулалтыг өөрчлөн худалдаа, үйлчилгээ гаргасан орон сууцны суурийн болон сууцны давхарт
- 10.3. Бүх төрлийн захын үйлчилгээний танхим буюу хашаанд түүнтэй шууд харьцах байр, өрөө тасалгаа
- 10.4. Үйлдвэр, нисэх буудлын зөвшөөрөгдсөнөөс бус байр, авто тээвэр, шалган бүртгэх товчоод болон шатахуун түгээх станцын байр
- 10.5. Аймаг, сумын гудамж талбайд байрласан түргэн үйлчилгээний цэг, мухлаг
- 10.6. Гэр хорооллын айлын хашаан дахь амбаар, мухлаг
- 10.7. Худалдааны төв, дэлгүүр доторх түрээсийн лангуу, тасаг

**Арван нэг: Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх
аж ахуйн нэгжийн хүлээх хариуцлага, үйл ажиллагаанд хяналт тавих**

- 11.1. Архидан согтуурахтай тэмцэх талаар гарсан Монгол улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, бусад эрх бүхий байгууллагуудад нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан шийдвэрүүд, хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн актыг зөрчвөл хууль тогтоомжинд заасны дагуу хариуцлага хүлээнэ.
- 11.2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг бусдад дамжуулан ашиглуулах, хуулбарлах, зөвшөөрөгдсөнөөс өөр цэгт байрлуулж үйлчлэх, Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлгүйгээр худалдан үйлчилвэл холбогдох эрх зүйн актанд засны дагуу арга хэмжээ авч Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг хүчингүй болгох, үйл ажиллагааг нь зогсоох хүртэл арга хэмжээ авна.
- 11.3. Хугацаатай үүрэг даалгаварыг биелүүлээгүй, давтан зөрчил гаргасан, татвар, нийгмийн даатгалын шимтгэл, бусад төлбөр хураамжийн өр үүсгэсэн, санаатайгаар орлогоо нуун дарагдуулсан аж ахуйн нэгжийн Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг хүчингүй болгох, үйл ажиллагааг нь зогсоох хүртэл арга хэмжээ авна.
- 11.4. Зөвшөөрөл нь хүчингүй болгогдсон аж ахуйн нэгж зөрчлөө арилгах, тавьсан шаардлагыг ханган аймгийн комисст дахин материал бүрдүүлж Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг дахин төлбөр төлж шинээр авна.
- 11.5. Улс, аймаг, орон нутгаас архидан согтуурахтай болон үйлчилгээний дэг журам сайжруулахтай холбоотой зохион байгуулж байгаа ажилд идэвхитэй оролцох
- 11.6. Аж ахуйн нэгж тогтоосон цагийн хуваарийг хатуу мөрдөж ажиллана.
- 11.7. Үйлчилгээний газрын дотоод дэг журам, орчны ариун цэвэр, хэв журмыг сахиулахад зөрчил гаргасан тохиолдолд аймаг, сумын хууль хяналтын байгууллагын өмнө хариуцлага хүлээнэ.
- 11.8. Энэ журмын хэрэгжилтэд аймгийн Засаг даргын Тамгын газар, сум, багийн Засаг дарга, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Стандартчилал хэмжилзүйн төв, Онцгой байдлын хэлтэс, аймгийн комисс хяналт тавина.